



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/340

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5, аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 035/26 дугаар дүгнэлт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 20 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндрэх онцгой эрсдэл үүсч, өвлийг хохирол багатай даван туулах зорилгоор сумдын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлтэд хяналт тавьж, гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

2. Архангай, Булган, Төв, Сэлэнгэ аймгуудад оторлож буй малчдад нүүрс тараах, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудад оторлож байгаа малчин өрхүүдэд түлээ нүүрсний үнийн дэмжлэг 48,533,750 (дөчин найман сая таван зуун гучин гурван мянга долоон зуун тавь) төгрөг, гадны аймагт оторлоогүй үлдсэн малчин өрхүүдэд хямдралтай үнээр өвс, ногоон тэжээлийн үнийн зөрүү 188,900,000 (нэг зуун наян найман сая есөн зуун мянга) төгрөг нийт 237,433,750 (хоёр зуун гучин долоон сая дөрвөн зуун гучин гурван мянга долоон зуун тавь) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

3. Гадны аймагт оторлоогүй үлдсэн малчин өрхүүдэд хямдралтай үнээр өвс, ногоон тэжээлийг нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дээрх зардлыг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101233

Аймгийн Засаг даргын 2020 оны 12
дугаар сарын 11-ны өдрийн 1540
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Арга хэмжээний нэр	Малчин өрхийн тоо	Нийт үнэ
1	Гадны аймагт отроор яваа малчдад нүүрс тараах ажлын хэсэг, тээвэр, савлах зардал	1548	48,533,750
2	Гадны аймагт оторлоогүй үлдсэн малчин өрхүүдэд хямдралтай үнээр өвс, ногоон тэжээл нийлүүлсэн аж ахуй нэгжүүдэд шилжүүлэх үнийн зөрүү	14431	188,900,000
3	НИЙТ		237,433,750

-oOo-